# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2025 оны 08 сарын 28 өдөр Дугаар А/319 Улаанбаатар хот

"Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг (2025-2028)" батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г нэгдүгээр, Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт, Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг ханган, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, үр дүнг тайлагнаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 6 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

5. Төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг жил бүрийн 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв (С.Энхболд)-д үүрэг болгосугай.

6 . Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД Ж.ЧИНБҮРЭН

141251735

# СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2025-2028)

## Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчнүүд тулгамдсан асуудал хэвээр байгаагийн нэг нь сүрьеэ өвчин юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2021 онд Монгол Улсыг сүрьеэгийн дарамт өндөртэй орны жагсаалтад оруулсан бөгөөд сүрьеэгийн өвчлөл 100,000 хүн амд 491 байгаа нь дэлхий болон Номхон далайн баруун бүс (НДББ)-ийн улс орнуудын дунджаас 3.7 дахин өндөр байна.

Манай улсад 2024 онд нийт 3002 сүрьеэгийн тохиолдол бүртгэгдсэн бөгөөд илрүүлэлт 20.1%-тай байна. Эмэнд мэдрэг сүрьеэтэй бүртгэгдсэн тохиолдлын 81,6% нь шинэ тохиолдол байна. Хүүхдийн сүрьеэгийн 173 тохиолдол бүртгэгдсэн нь нийт шинэ тохиолдлын дотор 7% эзэлж байгаа бөгөөд энэ нь 2023 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Уушгины шинэ халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эдгэрэлтийн хувь 72%, эмчилгээний амжилт 80% байна. Рифампицин/Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 156 тохиолдол, нэг буюу цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 112 тохиолдол бүртгэгдсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн орнууд дэлхийн эрүүл мэндийн чуулганаар "Сүрьеэг устгах дэлхийн стратеги"-ийг баталж, сүрьеэгийн тархалтыг эцэс болгох, 2035 он гэхэд нас баралтыг 2015 онтой харьцуулахад 95%, шинэ тохиолдлыг 90%-иар бууруулах, сүрьеэгийн улмаас санхүүгийн дарамтад өртөж буй өрхийн эзлэх хувийг тэглэх  зорилтыг дэвшүүлсэн.

Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг "Алсын хараа - 2050", "Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө болон ДЭМБ-ын "Сүрьеэг устгах дэлхийн стратеги", "Сүрьеэгийн стратеги төлөвлөгөө боловсруулах удирдамж" зэрэг олон улсын болон Монгол Улсын Засгийн газрын бодлогод нийцүүлэн боловсруулав.

## Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг дэмжих хүрээнд салбар хоорондын хамтын ажиллагааны тогтвортой байдлыг хангах, сүрьеэгийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлж, сүрьеэгийн өвчлөл, нас баралтыг бууруулна.

2.2. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сүрьеэгийн тусламж үйлчилгээний бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох замаар сүрьеэгийн илрүүлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх;

2.2.2. Өвчтөн төвтэй тусламж үйлчилгээг өргөжүүлэх замаар сүрьеэгийн эмчилгээний амжилтыг нэмэгдүүлэх;

2.2.3. Сүрьеэгийн эм, тоног төхөөрөмж, халдвараас сэргийлэх хянах хэрэгслийг тасралтгүй хангах, тогтвортой байдлыг бүрдүүлэхэд Засгийн газрын санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх;

2.2.4. Сүрьеэгийн чиглэлээр дэмжлэгт орчныг бүрдүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

## Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж иргэн бүрд цаг алдалгүй, чанартай үйлчилгээ үзүүлэх;

3.1.2. үйлчлүүлэгчийн нэр төрийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

3.1.3 үйлчлүүлэгч төвтэй, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, нотолгоонд тулгуурлах;

## Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа

4.1. Арга хэмжээг 2025-2028 он хүртэл хэрэгжүүлнэ.

4.2. Сүрьеэгийн оношилгоо эмчилгээний төвлөрлийг сааруулж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний нэгж болох өрх, сумын эрүүл мэндийн төвд сүрьеэгийн түргэвчилсэн оношилгоог хийх, бүх шатны эрүүл мэндийн байгууллагад сүрьеэг заавал мэдээлэх тогтолцоог хөгжүүлэх, онош батлагдсан даруйд эмчилгээг цаг алдалгүй эхлүүлэх боломжийг бий болгох, эмч эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургана.

4.3. Өндөр эрсдэлтэй бүлгийн хүн амын дундах оношлогдоогүй сүрьеэгийн тохиолдлыг цээжний рентген зураг, молекул биологийн түргэвчилсэн шинжилгээ зэргийг ашиглан нийт хүн амын дунд эрт илрүүлэг зохион байгуулж, эмчилгээг цаг тухайд нь эхлүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлнэ. Ингэснээр халдварын тархалт, сүрьеэгийн өвчлөл, нас баралтыг бууруулна.

4.4. Нийт хүн амын сүрьеэ өвчний талаар мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлэх замаар тусламж эрэлхийлэх зан үйлийг өөрчлөх, сүрьеэгээс улбаатай ялгаварлан гадуурхалтыг бууруулна.

4.5. Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тандалт, өвчтөн төвтэй тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, халдварын хяналт сэргийлэлтийг бэхжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатанд сүрьеэгийн оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлж, өргөжүүлнэ.

## Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3. гадаадын зээл буцалтгүй тусламж;

5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Арга хэмжээний үр дүн.

6.1. Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

6.1.1. эрүүл мэндийн байгууллагуудын иргэдэд үзүүлэх сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

6.1.2. сүрьеэгийн илрүүлгийн түвшин нэмэгдэнэ;

6.1.3. үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг өргөжүүлж сүрьеэгийн эмчилгээний үр дүнг нэмэгдэнэ.

6.1.4. сүрьеэгийн тусламж, үйлчилгээний эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт сайжирч, санхүүжилт үе шаттай нэмэгдэнэ.

6.1.5. сүрьеэгийн чиглэлээр ажиллах эмч, сувилагч, хүний нөөцийн чадавх сайжирч, хүртээмж нэмэгдэнэ.

6.1.6. сүрьеэ өвчний талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, дадал сайжирч улмаар уг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг ,мэдээлэл нэмэгдэнэ.

---oOo---

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 08 сарын 28 өдрийн А/310 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028 ОН)

| № | Арга хэмжээ | Эх үүсвэр | Нийт төсөв (сая төгрөг) | Суурь түвшин | Хүрэх түвшин, үр дүн, төсөв | | | | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 он | | 2026 он | | 2027 он | | 2028 он | | | |
| | | | | | Хүрэх түвшин | Төсөв (сая, төгрөг) | Хүрэх түвшин | Төсөв (сая, төгрөг) | Хүрэх түвшин | Төсөв (сая, төгрөг) | Хүрэх түвшин | Төсөв (сая, төгрөг) | Үндсэн | Хамтрагч |
| **Зорилго: Сүрьеэгийн тусламж үйлчилгээний тогтолцоог оновчтой болгох замаар төвлөрлийг сааруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| **Зорилт 1.Эрүүл мэндийн тогтолцоонд сүрьеэгийн тусламж үйлчилгээний бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох замаар сүрьеэгийн илрүүлэлтийн түвшинг нэмэгдүүлэх** | | | | | | | | | | | | | | |
| **Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, оношилгоо, тандалт, дэгдэлтийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 1.1 | Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад суурилан үйлчлүүлэгчийн хандсан шалтгаанаас үл хамааран сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | | 2024 онд илрүүлсэн сүрьеэгийн тохиолдлын тоо-580<br>Сүрьеэгийн илрүүлэлтэд оролцож буй эрүүл мэндийн байгууллагын хувь-21.8% | ЭМ-ийн байгууллагад суурилсан сүрьеэ илрүүлэх журам боловсруулж, батлуулах<br>1200<br>25% | - | 2412<br>50% | - | 3600<br>70% | - | 4500<br>90% | - | ЭМЯ, ХӨСҮТ, ЭМДЕГ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| 1.2 | Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн хөтөлбөрүүдтэй уялдуулан сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | - | 2024 онд илрүүлсэн сүрьеэгийн тохиолдлын тоо-368 | 400 | | 500 | | 600 | | 700 | | ЭМЯ, ХӨСҮТ, ЭМДЕГ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| 1.3 | Сүрьеэгээр өвчлөх өндөр эрсдэлт бүлэгт чиглэсэн идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулах (ЭМС-ын А/38 тушаалын дагуу) | Улсын төсөв, Глобаль сан | 3,248 | 2024 онд сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын 20%-г үзлэг шинжилгээнд хамруулсан. | 30% | 2,803 | 50% | 445 | 60% | | 80% | | Аймаг, Нийслэлийн ЭМГ, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ, холбогдох ТББ | ЭМЯ, ХӨСҮТ, |
| 1.4 | Улаанбаатар хотын өвчлөл өндөр Баянзүрх, Хан-Уул дүүрэгт сүрьеэгийн илрүүлэлтийг зохион байгуулах | Глобаль сан | 1,984 | - | Илрүүлэлтийг зохион байгуулсан байна. | 992 | Илрүүлэлтийг зохион байгуулсан байна. | 992 | - | | - | | ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ | НЭМГ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Тамхитай тэмцэх дэлхийн өдрөөр тамхи татдаг иргэдийн дунд сүрьеэгийн үзлэг, шинжилгээг жил бүр зохион байгуулах | Улсын төсөв | 16 | - | Үзлэг шинжилгээг зохион байгуулсан байна. | 4 | Үзлэг шинжилгээг зохион байгуулсан байна. | 4 | Үзлэг шинжилгээг зохион байгуулсан байна. | 4 | Үзлэг шинжилгээг зохион байгуулсан байна. | 4 | ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| 1.6 | Эрүүл мэндийн байгууллагуудын дунд "Эрүүл-уушги" аяныг жил бүр зохион байгуулах | Улсын төсөв | 250 | - | - | | "Эрүүл-уушги" аяны удирдамж, шалгуур үзүүлэлтийг батлуулсан байна. | | "Эрүүл-уушги" аяныг зохион байгуулж шилдэг ЭМБ-ыг шалгаруулсан байна. | 125 | "Эрүүл-уушги" аяныг зохион байгуулж шилдэг ЭМБ-ыг шалгаруулсан байна. | 125 | ЭМЯ, ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ |
| 1.7 | Үндэсний хэмжээнд эмэнд тэсвэртэй сүрьеэгийн лабораторид суурилсан тандалтын тогтолцоог бэхжүүлж тогтвортой байдлыг хангах | Улсын төсөв Глобаль сан | 3,791 | 1. 2024 онд үндэсний хэмжээнд 55 ЭМБ GeneXpert/TrueNAT шинжилгээг хийж, лабораториор батлагдсан тохиолдлууд 100% рифампицинд тэсвэржилт тодорхойлох шинжилгээнд хамрагдаж байна.<br>2. Нян судлалаар батлагдсан тохиолдлын 35-40% изониазидад тэсвэржилт тодорхойлж байна.<br>3. Лабораториор батлагдсан ОЭТС/Риф тэсвэртэй тохиолдлыг >75% шинэ эмэнд тэсвэржилт тодорхойлох шинжилгээнд хамруулж байна<br>4. NGS аргад суурилсан ЭТС-ийн тандалт хийх чадавхи бүрдсэн. | 1- 80%<br>2- 50%<br>3- >80%<br>4- >50%<br>5. Сүрьеэгийн дэгдэлтийг баталгаажуулна. | 518 | 1- 100%<br>2- >60%<br>3- >85%<br>4- ОЭТС/РТС - 100%<br>Бусад ЭТС- 5%<br>Мэдрэг сүрьеэ- 5% хамруулна. | 1,157 | 1- 100%<br>2- >70%<br>3- >85%<br>4- ОЭТС/РТС - 100%<br>Бусад ЭТС-10%<br>Мэдрэг сүрьеэ- 5% хамруулна<br>5. Сүрьеэгийн дэгдэлтийг баталгаажуулна. | 1,057 | 1- 100%<br>2- >80%<br>3- >85%<br>4. ОЭТС/РТС- 100%<br>Бусад ЭТС- 10%<br>Мэдрэг сүрьеэ- 5% хамруулна<br>5. Сүрьеэгийн дэгдэлтийг баталгаажуулна. | 1,059 | ЭМЯ, ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ, Хорих 429-р анги, Энэрэл эмнэлэг, улсын 6 төв эмнэлэг, СЭМТ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8 | Лабораторийн оношилгоо гүйцэтгэж буй бүх шатны ЭМБ-ын сүрьеэгийн лабораториудыг чанарын гадаад үнэлгээнд хамруулах | Улсын төсөв Глобаль сан | 70 | 2024 онд түрхэц болон Genexpert шинжилгээ гүйцэтгэдэг 42 лабораторийг хамруулж байна | Түрхэц болон Genexpert/ TrueNATшинжилгээ гүйцэтгэдэг 55 лабораторийг хамруулна | 15 | Түрхэц болон Genexpert/ TrueNATшинжилгээ гүйцэтгэдэг 55 лабораторийг хамруулна | 15 | Түрхэц болон Genexpert/ TrueNATшинжилгээ гүйцэтгэдэг 80 лабораторийг хамруулна | 20 | Түрхэц болон Genexpert/ TrueNATшинжилгээ гүйцэтгэдэг 80 лабораторийг хамруулна | 20 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ, Хорих 429-р анги, Энэрэл эмнэлэг, 6 төв эмнэлэг, СЭМТ |
| 1.9 | ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлагаа лабораторийг жил бүр гадаад чанарын үнэлгээнд хамруулах | Улсын төсөв Япон улсын Эрдэм шинжилгээний хүрээлэн | 140 | Япон улсын сүрьеэгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ЧГҮ-ний хөтөлбөрт жилд 1 удаа эмэнд тэсвэржилт тодорхойлох фенотип болон генотипийн шинжилгээнд хамрагдаж байна. | Жилд 1 удаа эмэнд тэсвэржилт тодорхойлох фенотип болон NGS шинжилгээгээр хамрагдана. | 35 | Жилд 1 удаа эмэнд тэсвэржилт тодорхойлох фенотип болон NGS шинжилгээгээр хамрагдана. | 35 | Жилд 1 удаа эмэнд тэсвэржилт тодорхойлох фенотип болон NGS шинжилгээгээр хамрагдана. | 35 | Жилд 1 удаа эмэнд тэсвэржилт тодорхойлох фенотип болон NGS шинжилгээгээр хамрагдана. | 35 | ЭМЯ, ХӨСҮТ | - |
| 1.10 | Цахим мэдээллийн платформуудтай сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем /ТУБИС/-ийг холбох, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх | Улсын төсөв | 50 | 2023 онд ХУР төрийн мэдээлэл солилцооны системээс баталгаажуулах сервес авсан. (РД хайлт хийж, овог нэр, нас хүйс, гэрийн хаяг) | Мэдээлэл солилцох зураглалыг боловсруулсан байна | | Төрийн мэдээлийн нэгдсэн сан /ESB/-тай холбогдож мэдээлэл солилцсон байна. Эрүүл мэндийн үндсэн 7 системтэй холбогдоно. | 30 | Төрийн мэдээлийн нэгдсэн сан /ESB/-р дамжуулан анхан шат болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцсон байна. | 10 | Төрийн мэдээлийн нэгдсэн сан /ESB/-р дамжуулан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцсон байна. | 10 | ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ | Үндэсний дата төв |
| 1.11 | Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системийн /ТУБИС/ -ийн тогтвортой байдлыг хангах | Улсын төсөв | 114 | 2022 онд Үндэсний Дата төвд серверийг байршуулан мэдээллийн аюулгүй байдлыг хангасан. | Цахим бүртгэлийн мэдээллийн системийг боловсронгуй болгож, мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангасан байна | | Цахим бүртгэлийн мэдээллийн системийн өдөр тутмын завсар үйлчилгээ, мэдээллийН аюулгүй, тогтвортой байдлыг хангана. | 38 | Цахим бүртгэлийн мэдээллийн системийн өдөр тутмын завсар үйлчилгээ, мэдээллийН аюулгүй, тогтвортой байдлыг хангана. | 38 | Цахим бүртгэлийн мэдээллийн системийн өдөр тутмын завсар үйлчилгээ, мэдээллийН аюулгүй, тогтвортой байдлыг хангана. | 38 | ЭМЯ | ХӨСҮТ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.12 | Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн систем /ТУБИС/, TUB-mobile аппилейкшний хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлэх | Глобаль сан | 100 | 2023 онд TUB mobile аппликейшны хөгжүүлэлт хийгдсэн. | TUB-mobile апплейкшний хөгжүүлэлт хийж, туршилт хийсэн байна | 10 | Эрүүл мэндийн байгууллагууд апплейкшнийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна | 30 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээний заавар шинэчлэгдэх, шинэ инновац, технологи нэвтрүүлэх бүрт цахим бүртгэлийн системийн хөгжүүлэлт хийгдсэн байна. | 30 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээний заавар шинэчлэгдэх, шинэ инновац, технологи нэвтрүүлэх бүрт цахим бүртгэлийн системийн хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | 30 | ЭМЯ | ХӨСҮТ |
| 1.13 | Сүрьеэгийн оношилгооны сургалтын загвар лабораторийг бий болгох | Глобаль сан | 58 | - | Сургалтын зориулалт бүхий лабораторийн өрөөтэй болсон байна | 58 | - | - | - | - | - | - | ЭМЯ | ХӨСҮТ |
| 1.14 | ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг сүрьеэгийн шинжилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх | Улсын төсөв Глобаль сан | 8 | 2023 онд ХДХВ-ын халдвартай 189 хүнийг сүрьеэгийн үзлэг шинжилгээнд хамруулж, 74 хүн сүрьеэгийн далд халдвар оношлогдож, 13 хүнийг УСЭ-нд хамруулсан. | 15 | 2 | 15 | 2 | 15 | 2 | 15 | 2 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ |
| 1.15 | Сүрьеэтэй өвчтөнийг ХДХВ-ын халдвар илрүүлэх зөвлөгөө, шинжилгээнд хамруулах | Улсын төсөв | 148 | 2024 онд 91.6% | 92% | 37 | 92% | 37 | 92% | 37 | 93% | 37 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ |
| **Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, хяналт-шинжилгээ үнэлгээ, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| 1.16 | Бүртгэлийн судалгаа буюу өвчлөлийн тооцооллын судалгаа хийх (Inventory study with capture-recapture) | Улсын төсөв ОУБ | 900 | - | Судалгааны ажлын хэсгийг байгуулж, арга аргачлалыг батлуулж, ёс зүйн зөвшөөрөл авсан байна. | | Бүртгэлийн судалгаа буюу өвчлөлийн тооцоолын судалгаар хийсэн байна. | 900 | | | - | | ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.17 | Сүрьеэгийн тархвар зүйн үнэлгээ хийж дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах | Улсын төсөв ОУБ | 48 | ДЭМБ-ын дэмжлэгтэй 2014, 2018 онуудад хийгдсэн. | - | - | - | - | Тархвар зүйн үнэлгээг хийсэн байна | 48 | - | - | ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ |
| 1.18 | Сүрьеэгийн хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлэх | Улсын төсөв ОУБ | 15 | 2008, 2013, 2022 онуудад хийгдсэн. | - | - | - | - | Сүрьеэгийн хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээг хийсэн байна | 15 | - | - | ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, ЭМБ-ууд |
| 1.19 | Өвчтөний замналын судалгаа хийх /5 жил тутам/ | Улсын төсөв ОУБ | 21 | 2021 онд судалгаа хийгдсэн | - | - | Судалгаа хийж, үр дүнг танилцуулсан байна. | 21 | - | - | - | - | ЭМЯ, ХӨСҮТ | Лавлагаа шатлалын ЭМБ, аймаг, дүүргийн ЭМТ, ӨЭМТ, СЭМТ |
| 1.20 | Сүрьеэгийн чиглэлээр хүн амын мэдлэг, хандлага, дадал, зан үйлийг тодорхойлох судалгаа хийх | Улсын төсөв ОУБ | 25 | 2012 онд хийгдсэн. | - | - | Судалгаа хийж, үр дүнг танилцуулсан байна. | 13 | - | - | Судалгааг хийж, үр дүнг танилцуулсан байна. | 12 | ХӨСҮТ, НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ |
| 1.21 | Олон нийтэд түшиглэсэн сүрьеэгийн эмчилгээ, хяналтын үр дүнгийн судалгаа хийх | Улсын төсөв ОУБ | 32 | - | | | | | Судалгааг хийж, үр дүнг танилцуулсан байна. | 32 | | | ХӨСҮТ | ТББ |
| 1.22 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээний үндсэний хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах | Улсын төсөв | - | 2020 оны ЭМС-ын А/196 тоот тушаалаар "Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө" батлагдсан | Хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | ЭМЯ, ХӨСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| 1.23 | Эрүүл мэндийн байгууллагад тогтмол дэмжлэгт хяналт хийх, мэргэжил арга зүйгээр хангах, давтамжийг нэмэгдүүлэх | Улсын төсөв Глобаль сан | 291 | 2024 оны төлөвлөгөөний | Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын 80%-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 66 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын 85%-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 70 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын 90%-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 75 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын 95%-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 80 | ЭМЯ, ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.24 | Аймаг, дүүргийн түвшнээс анхан шатны түвшний сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангах | Улсын төсөв Глобаль сан | 172 | 2024 онд дэмжлэгт хяналтыг 280 сумын эрүүл мэндийн төв, 225 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 505 Нэгжид хүрч ажилласан. /90%/ | Анхан шатны ЭМ-ийн байгууллагын 90%-д сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэлж мэргэжил арга зүйгээр хангасан байна. | 43 | Анхан шатны ЭМ-ийн байгууллагын 91%-д сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэлж мэргэжил арга зүйгээр хангасан байна. | 43 | Анхан шатны ЭМ-ийн байгууллагын 92%-д сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэлж мэргэжил арга зүйгээр хангасан байна. | 43 | Анхан шатны ЭМ-ийн байгууллагын 95%-д сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэлж мэргэжил арга зүйгээр хангасан байна. | 43 | Аймаг, нийслэлийн ЭМГ, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ | Өрх, сумын ЭМТ |
| 1.25 | Төрөлжсөн мэргэшлийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт хийх, мэргэжил арга зүйгээр хангах | Улсын төсөв Глобаль сан | 29 | Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа МСТН, МСЭМХ, МӨАУМХ зэрэг ТББ-ууд УНТЭ, УХТЭ, ШУГТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүдийн лабораториудад дэмжлэгт хяналтаар давхардсан тоооноор 10 удаа очиж ажиллаж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан. | Төрөлжсөн мэргэшлийн болон хувийн хэвшлийн 20 ЭМБ-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 7 | Төрөлжсөн мэргэшлийн болон хувийн хэвшлийн 25 ЭМБ-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 8 | Төрөлжсөн мэргэшлийн болон хувийн хэвшлийн 30 ЭМБ-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 7 | Төрөлжсөн мэргэшлийн болон хувийн хэвшлийн 35 ЭМБ-д дэмжлэгт хяналт хийсэн байна | 8 | Аймаг, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ | ТББ |
| 1.26 | Уушгины бус сүрьеэгийн оношилгооны чадавхыг бэхжүүлэх | Улсын төсөв | 1,850 | Үндэсний болон орон нутгийн түвшинд эмгэг судлалын анхан шатны шинжилгээг ашиглаж байна. | ХӨСҮТ-д иммуногистохимийн шинжилгээ хийх чадавхитай болгох бэлтгэлийг хангасан байна | 503 | ХӨСҮТ-д иммуногистохимийн шинжилгээ хийх чадавхийг бий болгон шинжилгээг хийж эхлүүлсэн байна | 826 | Иммуногистохимийн шинжилгээг тогтмол хийх урвалж бодисоор хангах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийсэн байна | 347 | Иммуногистохимийн шинжилгээг тогтмол хийх урвалж бодисоор хангах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийсэн байна | 174 | ЭМЯ, ХӨСҮТ, | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ |
| | Сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийг сүрьеэгийн эмнэлзүйн тусламж үйлчилгээ, тандалт, менежмент, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр бусад улс орны сайн туршлага судлах, сургалтад хамруулж чадавхжуулах | Улсын төсөв ОУБ | 184 | 2024 онд олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэй нийт 4 удаа давхардсан тоогоор 10 гаруй эмч, мэргэжилтнүүдийг гадаад сургалтад хамрагдсан. | Эмч мэргэжилтэнүүдийг бусад улсын туршлага судлах, шинэ арга технологид сургах гадаад сургалтад хамруулсан байна. | 62 | Эмч мэргэжилтэнүүдийг бусад улсын туршлага судлах, шинэ арга технологид сургах гадаад сургалтад хамруулсан байна. | 62 | Эмч мэргэжилтэнүүдийг бусад улсын туршлага судлах, шинэ арга технологид сургах гадаад сургалтад хамруулсан байна. | 60 | | - | ЭМЯ, ЭМХТ, ХӨСҮТ | ОУБ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.28 | Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, үйл ажиллагааны хэвийн ажиллагааг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургах | Улсын төсөв ОУБ | 50 | 2019 онд сургалт зохион байгуулсан. | | | ЭМБ-ын тоног төхөөрөмж хариуцсан инженерүүдийг сургалтад хамруулсан байна. | 25 | | | ЭМБ-ын тоног төхөөрөмж хариуцсан инженерүүдийг сургалтад хамруулсан байна. | 25 | ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ, Хорих, Энэрэл, СЭМҮТ |
| 1.29 | Сүрьеэгийн зохицуулагч эмч нарыг эмнэлзүйн болон тандалтын ур чадварын сургалтад хамруулах | Улсын төсөв ОУБ | 64 | 2018 онд 2 удаа нийт 40 зохицуулагч эмчийг сургалтад хамруулсан. | | | Сүрьеэгийн зохицуулагч эмч нарыг 100% сургалтад хамруулсан байна. | 32 | | | Сүрьеэгийн зохицуулагч эмч нарыг 100% сургалтад хамруулсан байна. | 32 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ |
| 1.30 | Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад сүрьеэгийн эмчилгээний анхан шатны болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр сургалт зохион байгуулах | Глобаль сан | 66 | 2024 онд 40 сүрьеэгийн эмчийг сургасан байна | 80 сүрьеэгийн сувилагчийг сургасан байна | 33 | 80 сүрьеэгийн сувилагч сургасан байна | 33 | - | - | - | - | ХӨСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага |
| 1.31 | Олон нийтэд түшиглэсэн эмчилгээний хяналтыг өргөжүүлэх, ОНЭМА-г үе шаттайгаар бэлтгэх, сургах, ажиллуулах | Глобаль сан | 6,500 | 2024 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах ОНЭМА-г бэлтгэх сургалт 4 удаа зохион байгуулсан | ОНЭМА-н оролцоотой олон нийтэд түшиглэсэн эмчилгээ өргөжсөн байна. | 3,500 | ОНЭМА-н оролцоотой олон нийтэд түшиглэсэн эмчилгээ өргөжсөн байна. | 3,000 | - | - | - | - | ЭМЯ, ХӨСҮТ | ТББ |
| 1.32 | Үндэсний түвшинд сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зарцуулалтын үнэлгээг 2 жил тутамд хийж, үр дүнг хэлэлцэн, бодлогын зөвлөмж боловсруулан эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх | Улсын төсөв Глобаль сан | 121 | 2022 онд хийгдсэн. | Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зарцуулалтын үнэлгээг хийж, зөвлөмж гаргасан байна | 61 | | | Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зарцуулалтын үнэлгээг хийж, зөвлөмж гаргасан байна | 60 | - | - | ЭМЯ, СЯ, ДЭМБ, Глобаль сан, ХӨСҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ, аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМТ, БОЭТ, ЭМДЕГ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.33 | Цахим мэдээллийн системийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан сургалтын удирдамж, гарын авлага боловсруулах, сургах | Улсын төсөв | 65 | 2023 онд 300 гаруй эмч, эмнэлгийн ажилтанд цахим болон танхимын сургалт зохион байгуулсан. | ЭМА-ны сургалтын удирдамж, гарын авлага боловсруулсан байна | 5 | ЭМА-ны сургалт зохион байгуулсан тоо. | 30 | | | ЭМА-ны сургалт зохион байгуулсан тоо. | 30 | ЭМЯ, ЭМХТ | ХӨСҮТ, Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ, Хорих 429-р анги, Энэрэл эмнэлэг |
| **Эрүүл мэндийн байгууллагын халдварын хяналт, сэргийлэлтийг сайжруулах, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах** | | | | | | | | | | | | | | |
| 1.34 | Эрүүл мэндийн байгууллагуудын сүрьеэгийн халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээг үе шаттай хийх, нөхцөлийг сайжруулах | Улсын төсөв | 50 | ДЭМБ-ын дэмжлэгтэй 2024 онд ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникт хийгдсэн. | | | Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан байна. | 50 | - | - | - | - | ЭМЯ, ХӨСҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ, дүүргийн ЭМТ, НЭ, БОЭТ |
| 1.35 | Нийт хүн амын сүрьеэ өвчний талаар мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх замаар тусламж эрэлхийлэх зан үйлийг өөрчлөх, сүрьеэгээс улбаатай ялгаварлан гадуурхалтыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | Глобаль сан | 782 | 2024 он тендер зарлагдаж, мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж, 3 жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулсан. | Мэдээлэл сургалт сурталчилгааны чиглэлээр үнэлгээ хийж, ажлын төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. | 410 | Мэдээлэл сурталчилгаа өргөн хүрээнд зохион байгуулна | 372 | - | - | - | - | НЭМҮТ | ХӨСҮТ, ТББ |
| 1.36 | Үндэсний хэмжээнд дээд хэмжээний чуулган, уулзалтыг зохион байгуулах | Улсын төсөв | 200 | 2018, 2022, 2024 онуудад зохион байгуулсан. | - | - | Дээд хэмжээний уулзалт зохион байгуулсан байна. | 100 | - | - | Дээд хэмжээний уулзалт зохион байгуулсан байна. | 100 | ЭМЯ, ХӨСҮТ | ДЭМБ Хамтрагч байгууллага |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.37 | Үндэсний хэмжээнд "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө жил бүр боловсруулж, хэрэгжүүлэх | Улсын төсөв | 85 | Жил бүр үндэсний хэмжээнд "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. | Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаар хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 21 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаар хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 21 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаар хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 22 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаар хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 21 | Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ | ХӨСҮТ, НЭМҮТ, ДЭМБ, ТББ |
| 1.38 | "Сүрьеэгүй аймаг, сум/дүүрэг, хороо" зорилтот хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилүүлэх. | Улсын төсөв | 180 | 2025 онд Завхан аймагт "Сүрьеэгүй аймаг" зорилтот хөтөлбөрийг боловсруулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. | Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний төсөлд Сүрьеэгүй аймаг, дүүрэг зорилтот хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх тухай санал хүргүүлсэн байна. | | Сүрьеэгийн өвчлөл өндөр 8 аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд "Сүрьеэгүй аймаг, дүүрэг" санаачлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна. | 60 | 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд "Сүрьеэгүй аймаг, дүүрэг" санаачлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна. | 60 | 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээнд "Сүрьеэгүй аймаг, дүүрэг" санаачлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна. | 60 | Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, НЭ, БОЭТ, | ЭМЯ, ХӨСҮТ |
| **Зорилт 2: Сүрьеэгийн эмнэлзүйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр** | | | | | | | | | | | | | | |
| **Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ (оношилгоо, эмчилгээ)** | | | | | | | | | | | | | | |
| 2.1 | Орон гэргүй, ядуу, эмзэг бүлгийн сүрьеэтэй өвчтөнийг сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хамруулах, дэмжлэг үзүүлэх | Глобаль сан | 2,935 | Глобаль сангийн төслийн дэмжлэгтэй 2021-2023 онд МУЗН 100 гаруй хүнд хүрч ажилласан. | Зорилтот бүлгийн 450 өвчтөнд эмчилгээний хугацааны турш дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. | 1,468 | Зорилтот бүлгийн 450 өвчтөнд эмчилгээний хугацааны турш дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. | 1,467 | - | | - | | Аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн газар | Аймаг, нийслэлийн ЗДТГ, аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМТ, БОЭТ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
